# WECHAT QR CODE PAYMENT GUIDE (VIA SOCIALPAY)

## • БЭЛТГЭЛ АЛХАМУУД



1. Харилцагч та Social Pay аппликэйшн-д бүртгүүлсэн байх шаардлагатай.

   Та Social Pay аппликэйшн-д бүртгүүлж өөрийн мэдээллийг бүрэн баталгаажуулна.

2. Харилцагч та UnionPay олон улсын эрхтэй карттай байх шаардлагатай.

   SocialPay аппликэйшн-д бүртгүүлсний дараа UnionPay картаа 2 төрлөөр үүсгэх боломжтой.
   - SocialPay аппликэйшны Хэтэвч - Карт нэмэх товч дээр дарж виртуал карт үүсгэх
   - Интернэт банк болон дурын салбарт хандан биет карт захиалж авах

3. Харилцагч та өмнөх шаардлагыг хангасан тохиолдолд бусад төрлийн wallet аппликэйшн суулгах шаардлагагүйгээр SocialPay аппликэйшныг ашиглан Wechat-н төлбөр тооцоог хялбар хийх боломжтой.

Харилцагч та SocialPay аппликейшн-д бүртгүүлэх болон бусад дэлгэрэнгүй заавар мэдээллийг **https://socialpay.mn** хуудас руу хандан авах боломжтой.

## • WECHAT QR КОДООР ТӨЛБӨР ХИЙХ АЛХМУУД:



АЛХАМ 1
SocialPay аппликэйшн руу орж "QR" товчийг дарна.

АЛХАМ 2
Wechat QR кодыг уншуулна.

АЛХАМ 3
Төлбөрийн дүнг оруулна.

Wechat төлбөр төлөхөд тухайн өдрийн валютын (CNY) ханшаар бодогдохыг анхаарна уу. .



АЛХАМ 5
UNIONPAY картыг сонгон "Төлөх" товчийг дарна.

АЛХАМ 6
Social PIN буюу гүйлгээний 4 оронтой нууц кодыг оруулна.

АЛХАМ 7
Үргэлжлүүлсний дараа дэлгэц дээр гүйлгээ амжилттай гэх хариу гарч ирэх бөгөөд "Хаах" товчийг дарна.

SocialPay

## • UNIONPAY ВИРТУАЛ КАРТ ҮҮСГЭХ ДАРААЛЛЫН ГАРЫН АВЛАГА.



АЛХАМ 1
Та SocialPay аппликэйшны "Хэтэвч" цэс рүү орно.

АЛХАМ 2
"+" товчийг дарна.

АЛХАМ 3
Виртуал карт цэсэд харагдах "Үүсгэх" товчийг дарна.

АЛХАМ 4
UnionPay картын мэдээлэлтэй танилцаж, сонгоно.



АЛХАМ 5
Таны бүртгэлтэй гар утасны дугаарт очсон нэг удаагийн 4 оронтой кодыг оруулж "Үргэлжлүүлэх" товчийг дарна.

АЛХАМ 6
Үйлчилгээний нөхцөлтэй танилцаж "Үргэлжлүүлэх" товчийг дарснаар таны UnionPay виртуал карт амжилттай үүснэ.

АЛХАМ 7
Үргэлжлүүлсний дараа таны UnionPay карт амжилттай үүснэ.

АЛХАМ 8
Таны шинээр үүссэн UnionPay карт "Хэтэвч" цэс "Виртуал карт" хэсэгт харагдана.

Гарын авлага
**SOCIALPAY**
ОНЛАЙН БҮРТГЭЛ

SocialPay

## • SOCIALPAY ОНЛАЙН БҮРТГЭЛ



Та SocialPay аппликэйшныг татаж бүртгүүлэх товч дээр дарна уу.

Та өөрийн хувийн мэдээллийг үнэн зөв бөглөн үргэлжлүүлэх товч дээр дарна уу

E-Mongolia эсвэл банкны бүртгэлээ ашиглан ДАН систем рүү нэвтэрнэ үү

Таны бүртгүүлсэн дугаарт илгээсэн 4 оронтой баталгаажуулах кодыг оруулна уу.



Та өөрийн иргэний үнэмлэхийн урд ард хэсгийг иргэний үнэмлэхээ барьсан selfie зургаа оруулна уу.

Та өөрийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулан үргэлжлүүлнэ үү.

Та үйлчилгээний нөхцөл, гэрээтэй танилцан дэлгэц дээр гарын үсгээ зурж баталгаажуулна уу.

User гүйлгээний эрхгүй бол profile хэсгээс орж бүтэн эрх үүсгэх хүсэлт илгээх боломжтой.

Таны мэдээллийг системээс хянаж баталгаажуулсны дараа SocialPay-ийн бүртгэл амжилттай үүснэ.
Шинээр үүссэн хэрэглэгчийн өдрийн гүйлгээний лимит нь 1 сая төгрөг байна.

## • SOCIALPAY ИНТЕРНЭТ БАНКААР НЭВТРЭХ



Та SocialPay аппликэйшнлуугаа орж "Нэвтрэх" товч дээр дарна.

Нэвтрэх дэлгэцрүү орсны дараа "Интернэт банк" товч дээр дарна.

Интернэт банк дэлгэцрүү орсны дараа интернэт банкныхаа нэвтрэх нэр болон нууц үгийг оруулан үргэлжлүүлнэ үү.

Та интернэт банкны эрхээрээ амжилттай SocialPay аппликэйшнд нэвтэрлээ.